# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/353 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох,
тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх, хасах,
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3,19.21,19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 16 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 4 хуулийн этгээдийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлөөс чиглэл хасах 1 хуулийн этгээдийг гуравдугаар, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх 2 хуулийн этгээдийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлагсугай.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Эмийн сан, ариутгал, халдваргүйтгэлийн тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Жаргалд үүрэг болгосугай.

4.Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, Эрүүл мэндийн хяналтын хэлтэс /М.Мөнхгэрэл/-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг

газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д нарт тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.НАРАНБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 15 -ны өдрийн
А/353 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Ач-Үр ХХК /2670135/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | ЧД, 18-р хороо, ЭМОН плаза, 3-р давхарт |
| 2. | Жи Эй Эн анар мед ХХК /8477787/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | СБД, 1-р хороо, 13-р хороолол Энхтайваны өргөн чөлөө гудамж 38 тоот |
| 3. | Дорнын хатан фармаси центр ХХК /7208785/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | СБД, 11-р хороо, 7 хороолол, Эйс ти аппартмент 716-109 тоот |
| 4. | Сити фарм мэик ХХК /6627137/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | БЗД, 38-р хороо, Шархад хилчний гудамж, 431 байр, 1 давхарт 102 тоот |
| 5. | Сэрдог-Арур ХХК /5279429/ | Клиник | Уламжлалт анагаах ухааны өвчний тусламж, үйлчилгээ | ХУД, 3-р хороо, Хос даль центр 3 давхар 304 тоот |
| 6. | Атена дентал клиник ХХК /7199065/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ/ | ЧД, 2-р хороо, БЕРИШ Сентер, 6 давхарт |
| 7. | Вондер кардио ХХК /7201585/ | Клиник | Дотрын өвчний тусламж, үйлчилгээ | ХУД 4-р хороо, Арцатын ам/17100/, Наадамчдын зам гудамж, 1294-р байр, 257 тоот |
| 8. | Ганга лагшми ХХК /7044481/ | Клиник | Дотрын өвчний тусламж, үйлчилгээ, Эмнэлзүйн лаборатори | БГД, 6-р хороо, ААӨЧ гудамж, 76/2 тоот |
| 9. | Мөнх хишиг хулан ХХК /7111913/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог засал/ | БГД, 12-р хороо, Мөнгөн тайга төвийн 3 давхарт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. | Саннисмайл ХХК /5703174/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог засал, гажиг засал/ | БЗД, 2-р хороо, Их тойруу, Хоршооллын хотхон 60 байр үйлчилгээний 3 давхар А тоот |
| 11. | Селестиал гэрэл ХХК /7195049/ | Клиник | Уламжлалт анагаах ухааны өвчний тусламж, үйлчилгээ | БЗД, 25-р хороо Нарны зам, 13-р хороолол Ногоон төгөл хотхон 75-р байр 01 тоот |
| 12. | Очир нова И Эл Эм ХХК /7201121/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог засал/ | ХУД 23-р хороо, Нүхт Юнайтэд Молл үйлчилгээний төв 5 давхар |
| 13. | Мөнхөд атгах аз ХХК /7188361/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог засал, гажиг засал, шүдний өвчний мэс засал/ | БЗД, 25-р хороо, 13-р хороолол, Нарны зам гудамж, 147-р байр, 05 тоот |
| 14. | Сэржмядаг дагина ХХК /7197401/ | Клиник | Уламжлалт анагаах ухааны өвчний тусламж, үйлчилгээ | ХУД, 4-р хороо Яармаг наадамчдын зам 905/2 байр, 1давхар Y2 тоот |
| 15. | Юмэйно мачи ХХК /7091353/ | Клиник | Хүүхдийн өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ/ | БЗД, 1-р хороо, Токиогийн гудамж, Сайн костракшн байр, 4 давхарт |
| 16. | Зоргерс асаргаа ХХК /7195361/ | Клиник | Сувилахуйн төв | ХУД-ийн 2-р хороо, 26/3 байр 1 тоот |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 15 -ны өдрийн
А/353 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Одоо эрхэлж буй үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл |
|---|---|---|---|---|
| 1. | ХЧ андууд ХХК /2164981/ | Клиник | Шүдний өвчний оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог засал | Шүдний өвчний гажиг засал, шүдний өвчний мэс засал |
| 2. | Эрүүл энх баяс ХХК /5214181/ | Клиник | УАУ, Мэдрэлийн өвчний тусламж, үйлчилгээ | Дүрс оношилгоо |
| 3. | Өндөр зүрх ХХК /5502012/ | Клиник | Ерөнхий мэс засал, Нөхөн сэргээх пластик мэс засал, Арьсны өвчний тусламж, үйлчилгээ | Чих, хамар, хоолойн тусламж, үйлчилгээ, Андрологийн тусламж, үйлчилгээ |
| 4. | Неонгэгээ ХХК /5025656/ | Клиник | Эмэгтэйчүүдийн өвчний оношилгоо, эмчилгээ, Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ | Дотрын өвчний тусламж, үйлчилгээ |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 15 -ны өдрийн
А/353 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

СТС6091 9077456

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ ХАСАХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Одоо эрхэлж буй үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрлөөс хасах чиглэл |
|---|---|---|---|---|
| 1. | Баян улаан рөүд ХХК | Клиник | Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, нүүр амны өвчний согог, гажиг, мэс засал | Нүүр амны өвчний согог, гажиг засал |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 15 -ны өдрийн
А/353 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭД

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн дугаар | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| 1. | Сити фарм мэйк ХХК | Эмийн сан | ЭСХ-17/22/3554 | Зөвшөөрлийн тухай хуулийн 6-р бүлгийн 6.1-р зүйлийн 1.3 |
| 2. | Үйлс бүтэмж ХХК | Клиник | ЭХ-05/22/2528 | Зөвшөөрлийн тухай хуулийн 6-р бүлгийн 6.1-р зүйлийн 1.3 |